



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/570 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Плэйтийм При эвент” арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, “Улаанбаатар фүүд фестиваль 2026” олон улсын хоолны өдөрлөг арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд тус тус жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах зардлыг хууль журамд нийцүүлэн гаргахыг ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА

D. Batkhuyag

Д.БАТСҮХ



